



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/41

Хархорин сум

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 5.1, 5.2, 5.3, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, үнэлгээний асуудал хариуцсан комиссыг 2 дугаар, устгалын асуудал хариуцсан комиссыг 3 дугаар, худалдан борлуулах асуудал хариуцсан комиссыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлан, мэдээг заасан хугацаанд холбогдох байгууллагад тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга (Засаг даргын Тамгын дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

